

I-II/2021

Тархаасан: 2021 оны 04 дүгээр сарын 12




## Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2021 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өссөн байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 2 дугаар сард 146.5 болж, өмнөх оны мөн үеэс 34.0 хувь, өмнөх оны эцсээс 1.3 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 2 дугаар сард 149.1 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 40.9 хувь, өмнөх оны эцсээс 11.0 хувь, өмнөх сараас 6.6 хувиар тус тус өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 40.9 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 45.5 хувь (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 2 дугаар сард 101.7 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 5.2 хувь, өмнөх оны эцсээс 9.6 хувь, өмнөх сараас 6.6 хувиар тус тус өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөхөд тээврийн хэрэгслийн (машин) бүлгийн үнэ 52.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1. Гадаад худалдааны нөхцөлийн индекс<sup>1</sup> (2015=100), хувь



<sup>1</sup> Туршилт тооцоо

**Ойлголт, тодорхойлолт:**

**Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг** экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

**Экспортын үнийн индекс:** Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

**Импортын үнийн индекс:** Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

**Суурь үе:** Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

**Эх үүсвэр:** Гаалийн ерөнхий газар

**Ангилал:** Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 05 дугаар сарын 17



*Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Г.Мөнх-Оргил  
Утас : (976-51)-261561*

